



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 815

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын драмын эрдмийн театрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 24,900,000.00 (хорин дөрвөн сая есөн зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг данснаас хасч Булган аймгийн Орон нутгийн өмчийн газарт бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Улсын драмын эрдмийн театрын захирал Н.Наранбаатар, Булган аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Баттулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө данснаас хасах болон засаж сэлбэн ашиглах, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, үлдэгдэл өртөггүй хөрөнгийг үнэлж бүртгэх, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132003193

32-r_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ДРАМАЫН ЭРДМИЙН ТЕАТРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨНД БҮРТГЭЛТЭЙ,
ДАНСНААС ХАСЧ, ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр, марк, улсын дугаар	Арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ/ Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Хүлээн авч бүртгэх байгууллагын нэр
				төгрөг		
1	Тээврийн хэрэгсэл /Хьюндай Старекс маркийн 52-86 УНВ улсын дугаартай/	КМНВР81JP4U6 07123	2013.11.30	24,900,000.00	0.00	Булган аймгийн Орон нутгийн өмчийн газар
	Дүн			24,900,000.00 (хорин дөрвөн сая есөн зуу)	0.00	